

УУЛ УУРХАЙН НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Д. Намсрай¹, Д.Отгончимэг²

Хөгжиж байгаа орнуудын хөгжлийн түвшнөөс хамааран эдийн засгийн өсөлтийг хангах хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутмаг байх нь их. Энэ учраас эдийн засгийн чухал ач холбогдолтой төслийг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн эх үүсвэрээ бий болгох нь хүндрэлтэй асуудал байсаар байна. Ихэнх тохиолдолд хөгжиж байгаа орнууд нь хандивлагч орнууд болон олон улсын байгууллагуудын зээл, буцалтгүй тусламжид найдаж байна. Харин байгалийн баялаг ихтэй хөгжиж байгаа орнуудын хувьд эдийн засгийн хөгжлийн нэг гарц, илүү боломж нь энэ нөөц баялгаа зөв зохистой ашиглах явдал мөн. Ашигт малтмалаас олох орлогоо зөв хуваарилан цаашид урт удаан хугацаанд тогтвортой хөгжих нийгэм эдийн засгийн зохистой бүтцээ бий болгох нь байгалийн нөөц баялаг ихтэй хөгжиж байгаа манай орны хувьд чухал асуудал болж байна.

Манай улс гадаадын хөрөнгө оруулалтыг уул уурхайн салбарт татах үүднээс олон жилийн турш таатай орчинг бүрдүүлж ирлээ. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиар бодлогын таатай орчинг бүрдүүлж энэ хүрээнд олон арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн байна. Үүний үр дүнд 1990-ээд оноос хойш манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувийн жин 2 дахин, уул уурхайд ажиллагсадын тоо 2 дахин өсөж, улсын нэгдсэн төсвийн орлогын багагүй хувийг олборлох салбарын орлогын албан татвар бүрдүүлж байна. Энэ бүхэн бол манай улс уул уурхайн салбарын хөгжлийг дэмжиж ирсэнтэй холбоотой бөгөөд дээрхи хугацаанд нийгэм эдийн засгийн сайн үр дагаварын хажуугаар бусад сөрөг үр дагавар ч байсаар байгаа нь тодорхой. Өнөөдөр манай улсад хөгжлийн гарц болохуйц уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр төслүүд эхлэлийн байдалтай байгаа ч тэдгээрийн нөлөөлөлийн бүсэд бий болж байгаа нөхцлүүдийг судлаж, практик сургамжаас санаа авч сөрөг үр дагаварыг арилгаж байх нь “ашигт малтмалын хараал” гээчийг хүртэхгүй байх нөхцөл мөн.

Олон улсын практикт уул уурхайн компаниуд үйл ажиллагааныхаа нөлөөлөл, үр дагаварт хайхрамжгүй хандаж газар нутгийг сүйрүүлэх, байгалийн нөөцийг цөлмөн орхиж нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарах явдал нэлээд гарч байсан. Иймээс хариуцлагатай уул уурхай, нийгмийн хариуцлагын асуудалд онцгой анхаарах болсон байна.

Уул уурхайн компаниудын хувьд нийгмийн хариуцлагын санаачлага хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ орон нутагт голчлон анхаарал хандуулах шаардлагатай болдог. Манай улсад

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, доктор (Ph.D)

² МУИС-ийн ОУХС-ийн багш, доктор (Ph.D)

үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн томоохон компаниуд орон нутагт чиглэсэн хөтөлбөр төслүүд хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал Оюу Толгой (ОТ) уурхай байрлаж буй Өмнөговь аймгийн Ханбогд сум болон нөлөөллийн бусад бүс нутагт орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага, сайн дурынхантай хамтран тогтвортой хөгжилд хүргэх ажлуудыг хэрэгжүүлж эхэлсэн байна. ОТ-оос Өмнөговь аймгийн дөрвөн сумыг нөлөөллийн бүс нутгаар тодорхойлсон. Үүнд: ОТ-оос 45 км-т байдаг Ханбогд сум (3154 хүн амтай), түүнтэй залгаа Баян-Овоо сум (1574 хүн амтай), Манлай сум (2554 хүн амтай) болон аймгийн төв Даланзадгад сум (17990 хүн амтай) орж байна.

Уурхай байгуулагдахаас өмнөх үеийн байгалийн төрхийг судалж, олборлолт дууссаны дараа нөхөн сэргээж, хамгаалах зорилгоор Өмнөговь аймгийн 2008 оны нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгааг хийж гүйцэтгэжээ. ОТ төслөөс нөлөөллийн бүсэд боловсруулж хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг дурьдвал: Эдийн засаг, бизнесийн хөгжилд чиглэсэн хөтөлбөрүүд, Дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр, Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр, Соёлын өвийг хамгаалах хөтөлбөр, Орон нутгийн оролцоот байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, Боловсролыг дэмжсэн төслүүд байна.

ОТ-йн нөлөөллийн бүсэд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын (ЭМААБ) асуудлаар явуулах судалгааг 2010 оны 10 дугаар сард хийж гүйцэтгэлээ. Судалгааны явцад ОТ нөлөөлөлийн бүс дэх олон нийтийн санал бодлыг нутгийн иргэд, шилжин ирэгсэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, малчид, уурхайн ажилчдыг оролцуулан санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлж, чанарын судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэсэн юм. Судалгааны үр дүнг “Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал хөтөлбөр”-ийг боловсруулахын өмнөх үнэлгээнд ашиглах зорилготой юм. ОТ нөлөөлөлийн бүсэд ЭМААБ-ын судалгааны зарим үр дүнгээс дурьдвал дараахь байдалтай байна.

Оюу толгойн нөлөөлөлийн бүсийн дөрвөн сумын нийт судалгаанд оролцогчид нь ажилчдын хувьд хамгийн тулгамдсан асуудлыг “Гэр бүлд ээлгүй хөдөлмөр эрхлэлт” бий болж байна гэж үзлээ. Тухайлбал Оюу толгой уурхайн үйлчилгээний CIS(company of international services) компанийн ажиллагсдын дийлэнхи нь бусад аймаг сумдаас ирж ажиллагсад бөгөөд тэд Ханбогд сумын төвд байгуулсан гэр кемпэд байрлаж байна. Энэ кемпэд гэр орноосоо тусдаа удаан хугацаагаар ажиллаж амьдарч байгаагаас ажиллагсадын ар гэрт ньэмэгтэйчүүд, хөгшдийн ачаалал ихдэх, хүүхэд эзэнгүйрэх, өрх толгойлсон хүүхэд бийболох, хүсээгүй жирэмслэлт, аборт, тохиолдын бэлгийн харилцаанд орох, бэлгийн замын халдварт өвчин ихсэх,гэр бүл салах сөрөг үзэгдлүүд гарч эхлэлээ гэж үзэж байна. Оюутолгойд ажиллахын тулд гэр бүлээрээ шилжин ирэх боломж хязгаарлагдмал байна. Засгийн газрын тогтоолоор Ханбогд суманд газар олголтыг зогсоосон учраас шилжин ирэгсэд айлын хашаанд түрээс төлөн гэрээ барих болжээ. Ажилд орох эсэх нь Ханбогд суманд шилжин ирээд 3 сар болсны дараа шийдэгддэг. Гэр бүлийн бусад гишүүд ялангуяа эмэгтэйчүүдэд ажлын байр олдохгүй байгаа зэрэг хүндрэлүүд нь гэр бүлээрээ шилжин ирэхэд бэрхшээл учруулсаар байна. Эндээс үзвэл ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг зохион байгуулахдаа тэдний нийгмийн асуудлыг орхигдуулж байгаа бөгөөд ажиллагсдыг Оюу Толгойн сайт доторхи гэр кемпболон Ханбогд сумын төвдэх гэр кемпэд олноор нь байрлуулахаар зохион байгуулсан нь энэхүү нөлөөлөлийн бүсд “Өрхөд ээлгүй хөдөлмөр эрхлэлт” бий болж эхлэснийг харуулж байна.

Судалгаанаас үзэхэд ажилчдын хувьд хүндрэлтэй байгаа бусад асуудлыг ач холбогдолоор нь авчүзвэл ажлын нөхцөл, хөдөлмөрийн хөлс, ажилчдын мэргэжлийн сургалт, ажлынцаг, хугацаа, ачаалал, ажилчдын өвчлөл, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой асуудлууд орсон байна.

Ханбогд сумын нутаг дахь Оюутолгой (ОТ) уурхай, Баян Овоо сумын нутаг дахь Коксын үйлдвэрийн ажилчдын хувьд ажлын байрны орчин нөхцөлтэй холбоотой хүндрэлүүд нилээд байна. ОТ уурхай дээр ажиллагсадтай ялгавартай шудрага бус харьцдаг, 40-өөс дээш насныхныг ажилд авдаггүй, хятад ажилчдын зүгээс янз бүрийн дарамт үзүүлдэг зэрэг хүндрэлүүдийг нэрлэсэн байна. ОТ уурхайн үйлчилгээний CIS компаний ажилчдын ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхцөл хүнд байгаа талаар судалгаанд оролцогсдын багагүй хувь санал гаргалаа. Коксын үйлдвэрт ажиллагсдын хувьд ажлын нөхцөл хүнд, хөдөлмөрийн хөлс бага байгаагаас гадна хоцрогдсон технологи ашиглаж байгаа, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл бүрэн биш зэргээс ажилчид хөдөлмөрийн хортой нөхцөлд өвчлөж байгаа, ойрхон орших Баян-Овоо сумынхны хувьд ч хордож байгаа талаар сумын иргэд санал гаргав.

Уул уурхайн нөлөөллийн бүсэд малчдын асуудлыг тусгайлан анхаарах шаардлагатай нь харагдаж байна. Одоогоор 10 хүрэхгүй цөөн малчин өрхийг ОТ уурхай болон олон улсын нисэх онгоцны буудал барих зорилгоор зохион байгуулалттайгаар нүүлгэн шилжүүлээд байгаа ч цаашид энэ бүс нутагт мал аж ахуйг хэрхэн хөгжүүлэх талаар одооноос анхаарах хэрэгтэй болжээ. ОТ уурхай, ТТ уурхай, авто зам, төмөр зам, олон улсын нисэх онгоцны буудал зэрэг томоохон бүтээн байгуулалтын явцад малчдын уламжлалт тайван амьдрал нэгэнт эвдэгдэж, бэлчээр, ус хязгаарлагдаж, аюулгүй байдал нь зөрчигдөх нь тодорхой байна. Нөлөөллийн бүсэд хийсэн судалгаагаар 4 сумын хэмжээнд малчдын тулгамдсан асуудлуудаас замын асуудал, усны гачигдал, тайван бус орчин, агаар хөрсний бохирдол, хүн малын эрүүл мэнд, малчдын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг зохицуулах зэрэгт тэргүүлэх ач холбогдол өгсөн байна.

Таван толгойгоос Гашуун сухайтын хилийн боомт руу нүүрс тээвэрлэж байгаа хүнд даацын олон машинууд хөрс бэлчээрийг талхлаж, байнгын дуу чимээ, тоосжилтийг бий болгожээ. Энэ нь бэлчээр тоосонд дарагдах, ургамлын бүтэцэд өөрчлөлт орох, хүн мал өвчлөхөд нөлөөлж байна. Одоогийн сургамжаас харвал онгоцны буудал барих, авто зам, төмөр зам тавихдаа нутгийн иргэдийн санал бодлыг сонсож, бэлчээр ус хязгаарлагдах нүүдлийн мал аж ахуйн онцлогийг харгалзан зохион байгуулалтын ажлыг урьднаас төлөвлөх шаардлагатайг харуулж байна.

Говь нутгийнхны хувьд усны хүртээмж, чанарын асуудал тулгамдсан асуудал байсаар ирсэн бөгөөд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой усны түвшин бүр шавхагдах вий гэсэн айдас нутгийн иргэдийн дунд бий болсон байна. Зарим багт өмнөх жилүүдэд 100 тэмээ усалдаг байсан худаг одоо 40 тэмээ услаж чадахаа больсон гэсэн баримт хэлж байна.

Нөлөөллийн бүс нутагт малчдын ажиллаж амьдрах орчинд сөрөг өөрчлөлтүүд их гарч байгаагаас малчдын тоо цөөрөх хандлагатай байна. Зудад малаа алдах, уул уурхайн томоохон бүтээн байгуулалтын явцад бэлчээр хязгаарлагдах, усны хомсдол, тоосжилт г.м олон шалтгаанаас малчид мал аж ахуй эрхлэх сонирхолгүй болох, хэт цөөн малтай болсноос малчид сумын төв рүү нүүж ажилгүй, орлогогүй хүний тоог нэмэгдүүлэх хандлага гарч эхлэсэн байна. Залуучууд нь уурхайд ажиллах хүсэлтэй байгаа ч мэрэгжилгүйгээс ажилд орж чадахгүй, ажилд орсон ч шинэ орчин, соёлд дасан зохицож цагийн нарийн дэглэмтэй ажиллаж чадахгүй зэргээр гологдох явдал их гарч байна.

Цаашид малчдын мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжих, зохион байгуулах, сургалт, сурталчилгаа, мэдээлэлээр хангах, зарим тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ч шаардлага гарч байна. Одоогоор малчдыг нүүлгэн шилжүүлэхдээ хашаа хороог шинэ нутагт барьж өгөх, зуны байшин барьж өгөх, ажилд ороход нь зуучлах зэргээр туслаж байгаа ч малчдаас авсан саналаар бол энэ ажилд сэтгэл дундуур байна. Нүүлгэн шилжүүлсэн малчид ихэнхидээ сумын төвд ирж суурин амьдралд шилжиж байна. Нүүдлийн малчдын амьдралын хэв маяг өөрчлөгдөх хандлага гарч болох ч тэднийг цаашид эрчимжсэн мал аж ахуй болон жижиг дунд үйлдвэр эрхлэх, мэргэжилтэй болж уурхайн бүтээн байгуулалтад оролцох бүхий л бололцоогоор хангах талаар анхаарах шаардлага гарч байна.

Сумын төвийн оршин суугчид усны чанар, хүртээмж, эрүүл мэндийн үйлчилгээ, дэд бүтэц, шилжих хөдөлгөөн, зам, бусад барилга байгууламж, агаарын бохирдол, орон нутгийн бизнесийн орчин, мэргэжлийн байгууллагын үйлчилгээ, чанар, олон нийтийн сургалт зэрэг асуудлыг тэргүүлэх ач холбогдолтой гэж үзлээ.

Усны хүртээмж, чанарын хувьд худгийн насос, шүүлтүүр эвдэрч ажиллагаагүй болсон, ундны усаа холоос зөөдөг, үйлдвэрлэл, аж ахуй эрхлэхэд тухайлбал хүнсний ногоо тарихад ус хүрэлцдэггүй байна. Эрдэс ихтэй хатуулаг усыг унданд хэрэглэснээр элэг, цөс, гэдэс, ходоод, бөөр, шүүдний зэрэг өвчлөл ихсэх болжээ.

Сумын төвийн оршин суугчид өвчлөл, эрүүл мэндийн үйлчилгээний асуудлыг чухалчлан тавьж байлаа. Усны чанар муугаас гадна тоосжилт ихсэж байгаатай холбоотой амьсгалын замын өвчин, харшил ихсэх, түүнчлэн зүрх судасны өвчин, хавдар (нялх хүүхэд тархины хавдартай болсон) залуужиж байгааг цохон тэмдэглэж байна. Залуучуудын дунд аборт, зүрхний өвчин өсөж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд эмийн хангамж нийлүүлэлтэд муугаар нөлөөлж буй “тендэр”, төсөв хүрэлцэхгүй, ажиллагсдын мэдлэг, харилцааны соёл, жирэмсэн эмэгтэйчүүд аймгийн төвд очиж төрөх болсонтой хүндрэлүүд, хүний нөөцийн менежмент хангалтгүй зэрэг асуудлууд тулгамдаж байна.

Дэд бүтэц, зам барилга, хот байгуулалтын асуудлыг ялангуяа Ханбогдод нэлээд чухалчлан ярьж байна. Үүнд, 24 цагийн цахилгаан хангамж, цэвэр бохирын шугам, сумын төвийн оршин суугчид, шилжин ирэгсэдийн газрын асуудал, сумын төвийн хатуу хучилттай зам, Ханбогд, Баян-Овоо, Манлай сумаас ОТ руу явах хатуу хучилттай зам, замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ, автобусны буудалтай байх, сумын төвд явж буй том даацын машин, мотоциклын хөдөлгөөний аюулгүй байдал, зөвшөөрөгдөөгүй газраар зам гаргах болон мэргэжлийн байгууллагын үйлчилгээ чадамжийн асуудлууд орж байна.

Ханбогд, Даланзадгад руу чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой нийгмийн, эрүүл мэндийн үйлчилгээний төсөв хүрэлцэхгүй, газар, орон байр, дэд бүтэц, сургууль, цэцэрлэг, цагдаагийн байгууллагын ачаалал нэмэгдэж байна. Гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөн, тухайлбал Баян-Овоо, Манлай сумаас иргэд олноороо нүүж байгаагаас хүн ам цөөрч бизнес хумигдах, сургууль, цэцэрлэгийн дүүргэлт буурч байна.

Нөлөөллийн бүх суманд орон нутгийн бизнесийг хөгжүүлэхэд ОТ, бусад уул уурхайн бололцоо боломжийг ашиглах стратеги үгүйлэгдэж байна. Орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид хоол хүнс, ажлын хувцас г.м. нийлүүлэх боломжтой. Гэвч хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхэд лабораторийн шинжилгээ шаарддаг, мөн тухайн компани, аж ахуй нь 3 жил үйл

ажиллагаа явуулсан байх зэрэг нь орон нутгийнхны хувьд хүндхэн шалгуур болдог байна.

Сумын төвийн иргэд эрүүл мэнд, хоол хүнс, гэр бүл, ЖДҮ, бизнес, эрх зүйн асуудлаар асуудлаарсургалт хэрэгцээтэй байгааг тэмдэглээд усны нөөц, гэр бүлийн байдал, тухайлбал гэр бүл салалт ямар байгаа талаар судалгаа хийх хэрэгтэй гэж байлаа.

Оюу толгой, Таван толгойн (ТТ) уурхайнууд, Баян-Овоогийн цементийн үйлдвэрийн нөлөөлөлийн бүсэд хийсэн судалгаанаас дараах дүгнэлт гарч байна. Үүнд:

Уул уурхайн нөлөөллийн бүсэд хамгийн эрсдэлтэй хэсэг нь малчид байна. ОТ,ТТ-н үйл ажиллагааны эерэг, сөрөг үр нөлөө малчдын ажиллах амьдрах орчиндөөрчлөлт оруулж байгаагаас сөрөг тал нь давамгайлж байна. ОТ, ТТ-н “бүтээнбайгуулалт”-ын бүс нутагт байгаа малчдын амьдралын тайван хэв маяг өөрчлөгдөж, малын бэлчээр талхлагдах, малгүй, ажилгүй, орлогогүй болох, ирээдүйдээ итгэлгүй болох, бухимдах, архидах үзэгдэл нилээд дэлгэрээд байна. Цаашдаа төмөр зам, авто зам, онгоцны буудал барихадбүс нутагт байгаа малчдын асуудлыг тусгайлан зохистой шийдвэрлэх шаардлага гарч байна.Малчдын газар, бэлчээрийн асуудлыг зохицуулж өгөх, малгүй болж суурин төвбараадсан малчдыг ажил мэргэжилтэй болгох, фермерийн аж ахуй, жижиг дунд үйлдвэр эрхлэхэд ньтуслах зохицуулах асуудал тулгарч байна.

Олон нийтээс дэвшүүлээд байгаа дараачийн тулгамдсан асуудлууд нь ажилчидтай холбоотой байна. ОТ, ТТ төслүүд болон Баян-Овоо суманд ажиллажбайгаа Коксын үйлдвэрүүдтэй холбоотой шийдвэрлэх асуудлууд нилээд гарч байна.Юуны өмнө уул уурхайн энэ бүс нутагт (ОТ,ТТ) гэр бүлд ээлгүй хөдөлмөр эрхлэлт бийболж байгааг судалгаанд оролцогчид дүгнэж байна. Ажил эрхлэлтийг шийдвэрлэх явцад ажиллагсдын амьдралын үнэ цэнэт (гэрбүл, үр хүүхэд) зүйл хамгаалалтгүй үлдэж байна. “Нийгмийн хамгаалал хөдөлмөр”- ийнасуудлыг цогцоор нь шийдэх зарчим алдагдаж болзошгүй байна.

Уул уурхайн бүтээн байгуулалтын нөлөөгөөр ОТ,ТТ нөлөөллийн бүс нутагт байгаа 4сумын хүн амын шилжих хөдөлгөөн ихэсч байна. Ханбогд, Даланзадгад сумын хүн амөссөнөөс эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хамгаалах үүрэг бүхийхолбогдох байгуулагуудын ачаалал ихсэх, хүртээмж багасах хандлагатай байна. Баян-Овоо, Манлай сумын хүн амын тоо багасах хандлага гарч энэ нь сумдын нийгэм-эдийнзасгийн хөгжлийн асуудлуудад хүндрэл учруулж болзошгүй. Хүн амын гадагш чиглэсэнурсгал нь сумын бизнесийг багасгах улмаар ажилгүйдэл ихсэх, хүн амын орлого буурах,ядуурал ихсэх болно. Энэ учраас хүн ам цөөрч байгаа сумдын ажил эрхлэлтийг дэмжих,ОТ,ТТ зэрэг томоохон төслүүдийн хүрээнд ЖДҮ эрхлэх дэмжлэг үзүүлэх хэрэгтэйбайна.Бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд ОТ, ТТ нөлөөлөлийн бүс нутагт хотбайгуулалтын бодлого дутагдаж байна.

Уул уурхайн нөлөөлөлийн бүсэд хийсэн энэхүү судалгааны үр дүнд үндэслэн “Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал хөтөлбөр” боловсруулах ажил эхлэсэн бөгөөд цаашид хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог ханган мониторинг үнэлгээг хийж байх хэрэгтэй байна.